

ТӨВ АЗИЙН НҮҮДЭЛЧДИЙН ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

3. БАТСАЙХАН

МУИС-ийн антропологи-археологийн тэнхм

Эдүгээ бидний үеийг хүртэл хадгалагдан ирсэн бичгийн сурвалжуудад Төв Азийн эртний нүүдэлчдийн түүхийн талаар тун хомс мэдээ занги байдаг боловч сүүлийн арав гаруй жилд бий болсон археологийн материалд үндэслээд нилээд тоймтой нэхэн сэргээлт хийх бололцоо гарч байна. Энэхүү хуримтлал нь бидний мэдлэгийн дутууг аажмаар баяжуулж байгаагийн зэрэгцээ түүнийг зайлшгүй нягтлан хянах зарим нэг тогтсон ойлголтыг эргэн харахад хүргэж байгаа юм. Түүнчлэн, тухайн газар нутагт иргэншин сууж асан эртний нүүдэлчдийн угсаатны бүрэлдэхүүн соёлын хөгжилд үзүүлсэн янз бүрийн хүчин зүйлийн нөлөөллийг тогтоох нь ихээхэн чухал ач хөлбогдолтой. Ийм хүчин зүйлүүдийн тоонд баруун зүгийн эртний нүүдэлчдийн холбоо харилцааг дурдах хэрэгтэй. Судлаачид дээрх харилцаа холбоог харуулах зарим нэг чухал мэдээ баримтыг тэмдэглэсэн байдаг боловч суурь мэдээ баримтын хомсдолоос шалтгаалаад асуудлыг гүнзгийрүүлэн судлаагүй байна. Үүний зэрэгцээ археологийн судалгааны материал өсөн нэмэгдэхтэй зэрэгцэн палеоантропологийн баримт баталгаа гарч ирж байна. Анх Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутаг Наймаа толгой хэмээх газарт малтан судалсан 20 гаруй хүннү булшнаас европжуу төрхтөний гавал олдож байсан бол сүүлийн жилүүдэд мөн аймгийн нутагт зохион явуулсан хээрийн судалгаагаар өөр хэд хэдэн газраас олдлоо. Тухайлбал, Өгий нуур сумын нутаг Тамирын Улаан хошуу /Бурхан толгой/ хэмээх газарт шинээр илэрүүлэн олсон 280 гаруй хүннү булштай газарт малтан судалсан 16 булшнаас гарсан 5 бүтэн мөн эндээс холгүй 10 км орчим зайтай газарт орших Эмээл толгойн 7 булшаас 2 бүтэн илэрхий европжуу төрхт хүннү нарын гавал олноод байна.

Эдгээр булшуудын гадаад хэлбэр төрх, булшинд дагуулан тавьсан эд өлөг нь Монгол, Өвөр Байгаль зэрэг газарт малтан судалсан жинхэнэ хэв шинжит хүннү булштай ижил боловч зарим нэг ялгаа байгааг дурдвал: булшны нүх харьцангуй гүн 3-4 м. дүнг болон шургааган хашлага зонхилох бөгөөд, зүг чигийн хувьд өргөрөгийн дагуу байрлал цөөнгүй тохиолддог, адуу мал, зэр зэвсгийн зүйл ховор, 4-5 ширхэг ваар дагуулан тавьдаг гэх мэт анхаарал татахуйц онцлог шинж тэмдэгүүд байгаа юм. Малтан судалсан ихэнх булшууд маш их тоногдсон байсан боловч зарим булшнаас хүрэл хонх, цөгцөн ёроолт бүтэн хүрэл тогоо, дэнгийн төмөр цөгц, төмөр суулга, ясан эдлэлүүд, шавар сав суулга зэрэг эд өлгийн зүйлс гадраг.

Оршуулгын зан үйлд ажиглагдаж буй өмнө өгүүлсэн онцлогууд нь хүннүгийн бүрэлдэхүүнд багтан орж соёлын хувьд бүрэн өөрчлөгдсөн харь гаралтан овог аймгуудын угсаа гарвал, аж ахуй соёлын онцлог монгол газар эрхлэн залгуулж байсан алба үүрэгтэй холбоотой бололтой.

Түүнчлэн Тамирын улаан хошуунаас Баруун зүгт 5 км гаруй зайтай орших Хэрмэн тал хэмээх газарт зэрэгцээ гурван хэрмийг шинээр илрүүлэн олсон боловч дурсгалын он цагийг хараахан тогтоогоогүй байна. Тэгэхдээ уг хэрмүүд нь хүннүгийн бусад хэрэм бэхлэлтүүдтэй бүтэц, зохион байгуулалтаараа ижил төстэй тал ажиглагдаж байгаа бөгөөд Тамирын улаан хошууны булштай холбоотой байж болох талтай.

Сурвалжийн мэдээ сэлтээс үзвэл умардын хүннү нар хуньюй, цюйшэ, динлин, гэгунь болон синьли г.м овог аймгийг эзлэн авсаныг дурдсан байдаг. Гэхдээ

эдгээр аймаг улсыг умардын гэж онцлон тэмдэглэсэн байдгаас үзвэл тэд хүннүтэй хаяа нийлэн умард этгээдэд сууж асан нүүдэлчид байсан бололтой юм. Түүнчлэн МЭӨ 176 онд Маодун шаньюйгаас Хан улсын эзэн хаанд илгээсэн нэгэн захидалд “баруун сянь-ванг шийтгэж баруун зүгт юэчжийн эсрэг илгээв. Тэнгэрийн ивээлээр цэрэг, дарга нарын лагшин тунгалаг, агт тарган байж, надад юэчжиг устган буулгаж авах завшаан тохиов. Би лоулань, усунь, хуцзе болон тэдэнтэй хөрш хорин зургаан эзэмшлийг номхотгосонд бүгд хүннүд дагаар оров. Ийнхүү, нум татагч бүх ард түмэн нэгэн гэр бүлд багтав” (Таскин 1968:43) гэж өгүүлснээс үзвэл хүннүгийн бүрэлдэхүүнд зүүн зүгт оршин сууж асан дунхугаас гадна умард, өрнөдийн нийлсэн гуч гаруй их бага овог, аймаг улс нэгдэн нийлж хүннүгийн улс гүрэнд хүчээ өгч эхэлсэн ажээ. Ийнхүү Хүннүгийн бүрэлдэхүүнд зөвхөн угсаа гарвалын хувьд төдийгүй арьстны хувьд өөр өөр төрхтний төлөөлөгчид оролцож хожмын түрэг монгол угсаатан бүрэлдэн тогтох тэдний бие даасан нүүдлийн өвөрмөгц соёл бий болоход зохих үүрэг гүйцэтгэсэн бололтой.

Тухайн үед болж өнгөрсөн түүхэн үйл явдалыг сурвалжийн мэдээгээр мөшгөн үзэхэд Маодун шаньюйн захидалд нэр цохон тэмдэглэсэн үсүн аймаг нь хүннүтэй хаяа нийлэн сууж бусдаас илүү шадар холбоотой явж иржээ. Усунь нарын тухай анхны мэдээ МЭӨ II зууны үед гарч байна. МЭӨ 138 оноос эхлэн Хан улсын эзэн хаан У дигийн зарлигаар “Баруун этгээдийг” тандан, цэрэг хөдөлгөх тохиромжтой замыг сонгохын тулд Чжан Цянь тэргүүтэй элчийг илгээсэн боловч тэд хүннүгийн нутгаар дамжин гарах гэж байгаад баригдан шаньюйд хүргэгдэн ирж арван жил олзлогдон суусны эцэст сая боломжийг ашиглан юэчжид ирж эндээс Даваньд очоод нутаг буцжээ. Тэрээр хоёр дахь удаагийнхаа аялалаар усунь, эртний Дорнод Перс буюу Аньсид зэрэг баруун хязгаарын олон газар орноор явах завшаан тохиолдсон ажээ. Үсүн нар анх Цилян ба Дуньхуаны хооронд оршин сууж байгаад баруун зүгт одож Долоон голд очиж суурьшсан. Мөн усуний тэргүүнийг Гуньмо гэх ба манай эриний заагт үсүний Чигучэн хот тухайн үеийн улс төрийн төв их торгон замын худалдаа арилжааны нэгэн чухал газар байсан зэрэг Хан улсын хувьд ихээхэн ач холбогдолтой мэдээллийг анх дамжуулжээ.

Тухайн үед үсүн нар Хүннү улсаас бүрэн хараат байсан боловч хятадын Хан улс үсүнд өөрийн нөлөөгөө бэхжүүлэх талаар идэвхтэй бодлого явуулж байсны нэг жишээ нь МЭӨ 107 онд Хан улсын гүнжийг ихээхэн бэлэг сэлтийн хамт Гуньмод илгээх зэрэг өөртөө татах бүхий л оролдлогийг хийж байлаа. Мөн энэ үеэр шаньюй өөрийн охиныг Гуньмод нэгэн зэрэг өгч байснаас үзвэл (Бичурин 1950:192) дээрх хоёр их улсаас үсүнийн талаар баримтлах бодлого ихээхэн өрсөлдөөний дунд явагдаж байсны эцэст дотоодод нь зарим өөрчлөлт гарахад хүргэсэн бололтой.

МЭӨ 73 онд Хүннү гүрний жишээгээр үсүн нар газар нутгаа зүүн, баруун төвийн гэж гурван жигүүрийн зохион байгуулалтад оруулж төв хэсэгт нь гуньмо сууж бусад жигүүрийг захирах болсон байна. Гэвч удалгүй МЭӨ 64-51 оны хооронд Хан улсаас үсүний талаар явуулж байсан бодлогыг эсэргүүцсэн ард олны бухимдал газар авахын хамт хүннү гүнжээс төрсөн үе залгамжлагч гуньмог дагалдагчид олон нийтийн дунд давамгайлах болсон байна. Ийнхүү үсүний газар нутаг хоёр хэсэгт хуваагдан их, бага гуньмо бий болж нэгэн үе хурц зөрчин тэмцэлийн дунд оршиж байжээ. Энэ байдал нь Хятадын Хан улсын хувьд ихээхэн ашигтай байлаа. Юуны өмнө үсүн, хүннү хоёрын холбоог бүрэн таслаж, цаашилбал хүннүгийн эсрэг хөдөлгөх хүч болгон ашиглах. Нөгөө талаар Их тогон замыг бүрэн эрх мэдэлдээ оруулах боломж гарах байлаа. Гэтэл Хүннү улсын хувьд өөрийн хараат газар нутгийг алдаснаар Их торгон замыг хараа хангалтаасаа гарахад хүргэх байлаа.

Ийнхүү үсүний дотор болж байсан энэхүү зөрчил тэмцэл өрнө дорныг чиглэсэн миграцийн нэг гол шалтгаан нь байж болох ба хэд хэдэн удаа давтагдсан бололтой.

Сурвалжид өгүүлснээр үсүн нар билчээр ус даган нүүдэг малчин нүүдэлчид байсан бөгөөд зан заншил соёлын хувьд хүннүтэй төстэй байсан нь монгол нутагт хялбархан идээшин дасахад хүргэсэн байж болно. Гэвч зарим нэг дам мэдээгээр үсүн аймгийн ямар нэг хэсэг нь юу ч атугай МЭӨ 138 оноос өмнө ирж суурьшжээ гэж үзэж болохоор байна. Тухайлбал МЭӨ 138 онд Хан улсын У ди хааны томилон явуулсан элч Чжан Цянь замдаа олзлогдон Хүннүд 10 жил сууж хүннү эмэгтэйтэй гэр бүл болж хүүтэй болсон байжээ. Үүнээс үзвэл тэрээр хүннү хэл, ёс зан заншилыг сайн мэддэг байсан гэхэд хилсдэхгүй. Чухам энэ үед үсүний нэгэн сонирхолтой домгийг тэмдэглэн авчээ. Уг домогт Куньмогийн эцэг Нань-доу-ми хүннүгийн баруун хилийн жижиг ванлигийг захирч байв. Их юэчжи нар довтлон, Нань-доу- мийг алаад, нутгийг нь эзлэхэд хүмүүс нь хүннү рүү зугтаажээ. Амьд үлдсэн нялх Куньмогийн асрагч Бу-ци-шихоу нь түүнийг өлгийдөөд өвсөн дотор орхин, хоол эрхээр оджээ. Эргэж ирээд үзэхэд нөгөө хүүд өлөгчин чоно хөхөө хөхүүлж, мах зуусан хэрээ дээгүүр нь эргэлдэж байв. Тэр асрагч түүнийг богд хүн гэж үзээд, хүннүд өргөн аваачихад шаньюй түүнийг энхрийлэн өсгөсөн байна. Чингээд куньмог том болохоор нь эцгийнх нь харьяат нарыг өгч цэрэг толгойлуулжээ (Сүхбаатар 1980:179) гэжээ. Энд гарч буй үйл явдал нь өгүүлэмж, өрнөлтөөр Төв Азийн эртний монгол, түрэг нүүдэлчдийн угсаа гарвалын домогтой төстэй харагдаж байгаа боловч түүхэн бодит үйл явцыг илүү үнэнээр тусгасан бөгөөд үсүн хүннү хоёрын эртний харилцаа, холбоо сүлбээ хэрхэн тогтсоныг харуулж байна.

Бичгийн сурвалжид үсүний аж ахуйн талаар бусад нүүдэлчдийн нэгэн адил “ өвс ус даган нэг газраас нөгөөд нүүдэллэн явдаг” гэх уламжлалт томъёололоор нэг талыг барин тодорхойлсон байдаг. Гэвч археологийн материал нь тэдний оршин сууж байсан бүс нутаг бүрд байгаль цаг агаарын нөхцлөөс шалтгаалаад аж ахуйн янз бүрийн хэв шинж байсныг харуулж байгаа юм. Эртний үсүнүүдийн булш суурингаас олдсон малын ясан дээр хийсэн статистик анализ нь мал сүргийн бүтэцийг тогтоох боломжийг бүрдүүлсэн байна. Актас 2-ийн бууц өвөлжээ (Дорнод Долоон гол), Луговийн толгойн сууринд (Баруун Долоон гол) хийсэн малталтаас гарсан малын ясны хэрэглэгдэхүүнээс үзэхэд үсүний мал сүргийн бүрэлдэхүүн нь хагас нүүдлийн мал аж ахуй дээр үндэслэсэн аж ахуй болохыг харуулсан байна. Долоон голын эртний үсүнчүүд хонь, адуу, үхэр, хоёр бөхт тэмээ, ямаа, илжиг зэрэг малыг өсгөн үржүүлж байсан, ялангуяа, баян чинээлэг хүмүүс нь 4000-5000 адуутай тухай сурвалжид тэмдэглэжээ (Бичурин 1950:196).

Мал аж ахуйн зэрэгцээ зарим газарт газар тариалан эрхэлж байсныг харуулах багаж зэвсгийн зүйл дээр өгүүлсэн Актасын өвөлжөө, бууцнаас газар боловсруулах чулуун зээтүү, хүрэл хадуурын хугархай зэрэг олдсоноос гадан үр тарианы ургамалыг боловсруулах 11 бүтэн, 15 хагархай самбар чулуу олджээ (Воеводский М.В. Грязнов М.П.:1938). Мөн дээрх суурингийн орчим газраас энгийн усалгаатай газар тариалангийн ул мөр илэрсэн байна. Энд 60-150 хүртэлх кв.м талбайд тарвасын төрлийн бололтой ногоо тарьж байсныг тогтоожээ.

Хагас нүүдлийн мал аж ахуй, газар тариалангийн хөгжил нь хувийн өмч хөрөнгө өсөн нэмэгдэх эдийн засгийн үндэс болжээ. Үүний нэг баталгаа нь янз бүрийн хэлбэр дүрстэй тамгаар гэрийн мал ялангуяа адууг тамгалж өөрийн өмч хөрөнгийг бусдаас ялган таних хамгаалах эрхийн үндсийг тавьсан хэрэг байжээ.

Үсүний оршуулгын байгууламжууд нь голын дагуу тохиолдох ба түрүү үеийнх нь цагираг хэлбэрийн чулуун дараастай байдаг ажээ. Нас барагчидыг ямар нэг авс, хашлагагүй нүх, эсвэл хойт тал руу нь хөндийлөн ухсан нүхэнд тэнгэр байдлаар баруун зүг толгойг нь чиглүүлэн тавьж толгойн ард, ба хажуу талд хоол хүнсний

зүйлтэй ваар сав, зэр зэвсэг, гоёл чимэглэлийн зүйлийг дагуулан оршуулдаг байжээ.

Судлаачдын үзэж байгаагаар Долоон голын үсүний булшуудыг хэмжээ болон эд өлгийн чанарын ялгаагаар нь гурван хэв шинж болгон үзжээ. Эхнийх нь 50-80 м. Голчтой 8-12 м. өндөр шороон булшууд бөгөөд дараасын доор эрэгтэй эмэгтэй хүний нэгээс хоёр баялаг булш байх ажээ. Хоёрдугаар хэв шинжийн булш нь 15-20 м. голчтой, 1 м. өндөр, дараасын доор нэгээс хоёр оршуулга байх бөгөөд 3-4 шавар ваар, модон суулга, жижиг хүрэл ба алтан чимэглэл, амьтны загварт урлагын маягаар хийсэн бүсний хүрэл товруу, хүрэл хутга, илд, гурван талт болон хавтгай хүрэл зэв зэрэг эд өлгийг дагуулан оршуулдаг байна. Энэ хэв шинжийн булшууд нь хэдэн зуугаар нэг бүлэг болон оршдог ажээ. Гуравдугаар хэв шинжийн булшууд нь хамгийн олон тоотой тохиолдох ба 5-10 м. голчтой, 30-50 см өндөр, нас барагчид нэгээс хоёр ваар сав, төмөр хутга хавчаар, зарим тохиолдолд хүрэл ээмэг, зүүлт зэрэг эд өлгө дагуулан тавьдаг байжээ. Харин зэр зэвсгийн зүйл ховор олддог тухай онцлон дурджээ.

Долоон голын үсүнүүдийн антропологийн хэв шинжийг дөрвөн үеэр харьцуулан үзэхэд (МЭӨ IY-II зуун, МЭӨ II-I, МЭ I-III, МЭ IY-Y зуун) арьстны хэв шинж нь дээрх хугацааны туршид тодорхой өөрчлөлт гараагүй болох нь харагдсан бөгөөд энэхүү хэв шинж МЭӨ III зуунаас хошуугүй бүрэлдэн тогтжээ.

Долоон голын үсүн нарын антропологийн үндсэн хэв шинж Тянь-Шаны нэгэн адил бага зэрэг монголжуу төрхтөний хольцтой европжуу төрхтөнөөс бүрдэж байсан боловч ерөнхий шинж төрх болон тусгай ясан дээр хийсэн судалгаанаас үзвэл үсүнчүүдэд андроновын хэв шинж давамгайлж байсан бөгөөд монголжуу төрхтөний хольц ерөнхийдөө бага байх боловч, зарим нэг гавалд нилээд тодорхой илэрдэг байна. Гэхдээ Тянь-Шаны материалыг Долоон голын үсүнчүүдтэй харьцуулахад монголжуу төрхтөний шинж тэмдэг илүү илэрч байгаа ажээ (Гинзбург, Тромифова 1972:150). Наймаа толгойгоос олдсон Европжуу төрхтөний гавлыг Дундад Азийн эртний овог аймгуудын палеоантропологийн материалтай харьцуулан үзэхэд үсүнтэй хамгийн ойролцоо байсан ажээ.

Гэхдээ европжуу төрхтөний комплекс шинж тэмдэг зөвхөн Наймаа толгой төдийгүй арай сулавтар хэлбэрээр Төв ба Дорнод монголоос олдсон гавалд илэрдэгийг судлаачид тэмдэглэжээ (Алексеев, Гохман, Түмэн 1987:123).

Хүннүгийн бүрэлдэхүүнд багтан орж явсан өөр нэгэн европжуу төрхтөн аймаг бол хуцзе зарим сурвалжид тэмдэглэснээр цзеху нар болно. Ма Чан-шоугийн нягталснаар бол хуцзе гэдэг нь хүннү цзеху хоёрыг хамтруулан ийнхүү хэлж байгаа бол цзеху, гэдэг дан цзе нарыг нэрлэх нэр гэж үзсэн байна. Гэхдээ хуцзе нарыг европжуу төрхтөн аймаг болох тухай сурвалжид тодорхой заалт байхгүй боловч зарим нэг дам мэдээ заалтаас үзвэл тэдний нэг хэсэг нь европжуу буюу холимог хүмүүс байж болохоор байна. Тухайлбал, Жань Минь “Чжао улсын хүмүүсийг дагуулан ирж язгууртан, язгуургүй, эр, эм, залуу хөгшнийг үл ялган, ху, цзе нарыг бүгдийг хяджээ. Алагдагсад 20000 гаруй болжээ. . . . Тэр цагт өндөр хамартай, их сахалтай хүмүүс нь алагдагсадын тэн хагасаас давав” гэжээ (Сүхбаатар 1980:176). Цзегийн тухай сурвалжид дурдахдаа “цзегийн өвөг нь хүннүгийн тусгай аймгийн цян цюйгийн удам” гэсэн байдаг бөгөөд хятадын түүхч Яо Вой-юань цзе аймгийн гарлыг Хан улсын үеэс эхлэн хятад сурвалжийн мэдээгээр улируулан судлаад угсаа гарвал, түүх зан заншил, гадаад төрх зэргээр нь хүннүгийн ноёрхолд байсан юэчжи аймагт хамаарагдахыг нотолсон бол судлаач Г.Сүхбаатар Дундад Азийн европжуу хүмүүс байсан гэж үзсэн байна (1980:176).

Ийнхүү хэрэглэгдэхүүнээс үзвэл хүннүгийн бүрэлдэхүүнд багтан орж тэдэнтэй зэрэгцэн сууж байсан үсүн, цзе хэмээх хоёр европжуу төрхтөн аймаг бидэнд

мэдэгдэж байна. Гэхдээ цзе нар хүннүгийн түүх соёлын нийтлэг бүрэлдэн тогтох үйл явцад хэрхэн оролцсон хийгээд хаагуур нутаглан сууж байсныг тогтоох өөр ямар нэг төрлийн сурвалж хараахан алга байна.

Тамирын Улаан хошуу, Эмээл толгой, Наймаа толгойн булшуудыг шууд үсүнийх гэж үзэх хангалттай баримт хараахан бий болоогүй байгаа боловч сурвалжийн мэдээнд үндэслэн урьдчилсан байдлаар дээрх газрын булшуудыг үлдээгсэд үсүн нар байсан гэж үзэж болохоор байна. Тэд МЭӨ III-зуунаас хожуугүй үеэс эхлэн Хүннү улсын оршин тогтох хугацааны турш нутгийн гүнд оршин сууж байсан бололтой бөгөөд соёлын талаар бүрэн өөрчлөгдсөн төдийгүй арьстаны хувьд ижилсэн уусаж антропологийн хэв шинж нь аажмаар зонхилгч арьстны тал руугаа өөрчлөгдөхөд хүргэсэн бололтой.

Тамирын Улаан хошууны булшинд ажиглагдсан зарим нэг онцлог нь тухайн булшыг үлдээгсдийн угсаа гарвал, соёлын онцлогтой холбоотой байж болох боловч оршуулгын зан үйлийн бүхий л элементээрээ Монгол, Өвөр Байгальд малтан судалсан хүннү булшуудтай ижил байна. Дурдсан онцлог бүхий дурсгалын тоонд одоогоор Солбийн хүннү булшуудыг оршуулан тооцож болох боловч палеоантропологийн хэрэглэгдэхүүн эдүгээ олдоогүй байна.

Эцэст нь өмнө өгүүлсэн газруудын оршуулгын зан үйлийн онцлогт үндэслээд хүннүгийн археологийн соёлын орон нутгийн нэг хувилбар гэж үзэж болохоор байгаа бөгөөд үсүн гаралтай хүннү нар шинэ эрин үеийн соёл, түүхэн нийтлэг түрэг монгол супер угсаатан бий болох үйл явцад нэгэн адил идэвхтэй оролцогчид байжээ. Энэхүү соёлыг тээгч популяцууд хүннүгийн баруун жигүүрийн нутгаар сууж байсныг нь бичгийн сурвалж болон археологийн судалгааны урьдчилсан үр дүн харуулж байна.

Ном зүй

1. Алексеев В.П., Гохман И.И., Түмэн Д. Краткий очерк палеоантропологии Центральной Азии. /Каменный век-эпоха раннего железа/ В Кн., Археология этнография и антропология Монголии. Новосибирск 1987.
2. Бичурин Н.Я. Собрание сведений о народах обитавших в Средней Азии в древние времена II. М-Л., 1950
3. Воеводский М.В., Грязнов М.П. Усуньские могильники на территории Киргизской ССР:-ВДИ, 1938, №3 (4)
4. Гинзбург Г.Г., Трофимова Т.А. Палеоантропология Средней Азии М., 1972
5. Исмагулов О. Антропологическая характеристика усуней Семиречья. ТИИАЭ АН Каз. ССР, т.16. Алма-Ата, 1962.
6. Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. УБ., 1980
7. Таскин В.С. Материалы по истории сюнну /по китайским источникам/ М., 1968